

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөл 2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, Монголбанкны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүүгийн зах зээлийн байдлыг олон нийтэд хэрхэн мэдээлж буй байдал, Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын компаниас өгсөн санал, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай болон Монголбанкны гадаад активын байршил, түүний эрсдэлийн байдалтай танилцаж, холбогдох албан тушаалтны сонголыг хэлэлцэв. Мөн Монголбанкны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газраас 2013 оны 2 дугаар улиралд хийсэн шалгалтын дүн, өр барагдуулах ажлын явцын тухай товч мэдээлэл сонсов. Холбогдох асуудлаар зохих шийдвэр гарган УИХ-ын холбогдох байнгын хороонд болон Монголбанкны удирдлагад хүргүүлэхээр тогтов. Үүнд:

Монголбанкны Олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааг мөнгө, банк санхүү болон мөнгөний бодлогын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, мөнгөний бодлогын шинэчлэлийг түлхүү сурталчлах чиглэлээр өргөжүүлэхэд анхаарч ажиллах; хөндлөнгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-ийн дагуу тооцоолох боломжийг судлан тогтоох ажлыг зохион байгуулах, Монголбанкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх асуудалд анхаарч тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх; гадаад валютын улсын албан нөөцийн удирдлага болон мөнгөний бодлогын уялдаа холбоог сайжруулахыг Монголбанкны удирдлагад зөвлөсөн байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ